БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН ЭМТ-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** БНА-2021/121/СТА-ТШЗ


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: Tsetsegmaa_1961@yahoo.com



Баянхонгор
2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/ .................... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.................... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.................... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.................... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .................... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.................... 9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .................... 12

3.Аудитын тайлан.................... 12

3.1. Ерөнхий зүйл.................... 12

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .................... 13

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.................... 13

3.4. Материаллаг байдал.................... 13

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .................... 14

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.................... 15

3.7. Шилэн дансны мэдээлэл .................... 17

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .................... 18

3.9. Аудитын илрүүлэлт .................... 18

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.................... 18

Аудитын зөвлөмж.................... 18

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .................... 18

Менежментийн захидал.................... 18

5. Хавсралт:Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.................... 19


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.18 № 2/34

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,879,386.99** | **24,709,893.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,879,386.99 | 24,709,893.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,433,869.00 | 14,960,697.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,216,096.00 | 10,209,839.00 |
| 35130 | Эм боох материал | 1,217,773.00 | 4,750,858.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 14,445,517.99 | 9,749,196.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 225,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,959,580.00 | 6,769,096.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 800,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 54,800.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,431,137.99 | 1,954,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **590,384,962.91** | **602,693,696.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 590,384,962.91 | 602,693,696.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 587,255,296.26 | 599,608,029.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 535,890,482.86 | 535,890,482.86 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -14,935,545.83 | -29,535,244.23 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,772,500.00 | 80,157,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,048,250.32 | -25,858,139.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 94,524,156.28 | 98,504,156.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,749,889.81 | -75,694,354.52 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,639,945.02 | 31,669,945.02 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,838,101.94 | -15,526,316.27 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,345,070.00 | 7,345,070.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,345,070.00 | -7,345,070.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,129,666.65 | 3,085,666.61 |
| 39301 | Програм хангамж | 670,000.00 | 670,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -468,333.35 | -512,333.39 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,928,000.00 | 2,928,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **607,264,349.90** | **627,403,589.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **199,500.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 199,500.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 199,500.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 199,500.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 199,500.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **607,064,849.90** | **627,403,589.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 607,064,849.90 | 627,403,589.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 295,911,043.12 | 295,911,043.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 295,911,043.12 | 295,911,043.12 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -64,153,272.03 | -43,814,532.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -64,153,272.03 | -64,153,272.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 20,338,739.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 375,307,078.81 | 375,307,078.81 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **607,264,349.90** | **627,403,589.39** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **400,838,917.10** | **466,924,908.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,439,409.10** | **60,806,528.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 24,439,409.10 | 60,806,528.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,439,409.10 | 60,806,528.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,439,409.10 | 60,806,528.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **376,399,508.00** | **406,118,380.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 328,936,800.00 | 352,350,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 328,936,800.00 | 352,350,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 2,485,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,485,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,196,000.00 | 29,150,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,196,000.00 | 29,150,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 23,266,708.00 | 22,131,780.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,239,788.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,026,920.00 | 22,131,780.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **391,700,646.02** | **446,586,168.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **391,700,646.02** | **446,586,168.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 387,942,440.02 | 444,407,290.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,577,629.00 | 284,216,428.00 |
| 210101 | Үндсэн цалин | 250,577,629.00 | 196,812,951.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 68,106,995.48 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 19,296,481.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,032,914.00 | 34,439,313.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,032,914.00 | 34,439,313.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,102,550.00 | 24,244,405.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,281,734.00 | 3,013,888.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 16,820,816.00 | 21,230,517.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,758,999.10 | 29,844,847.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,503,800.00 | 1,497,290.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,371,800.00 | 13,800,510.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,972,990.00 | 1,992,210.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,808,000.00 | 1,963,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 160,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,102,409.10 | 10,431,137.99 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,645,100.00 | 25,130,588.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,515,820.00 | 18,522,408.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,129,280.00 | 6,353,180.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 255,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,935,000.00 | 4,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,935,000.00 | 4,900,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,814,000.00 | 1,274,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,814,000.00 | 1,274,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,676,247.92 | 39,957,708.52 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,619,135.00 | 4,871,442.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,057,112.92 | 35,086,266.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,758,206.00 | 2,178,878.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,239,788.00 | 00.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,239,788.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 693,450.00 | 6,495.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 693,450.00 | 6,495.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,824,968.00 | 2,172,383.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,824,968.00 | 2,172,383.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **9,138,271.08** | **20,338,739.49** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,853,909.57 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,036,980.21 | 00.00 |
| 225003 | Хөрөнгө оруулалтын гарз | 1,816,929.36 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -2,853,909.57 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6,284,361.51** | **20,338,739.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **376,399,508.00** | **406,118,380.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **376,399,508.00** | **406,118,380.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 328,936,800.00 | 352,350,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 328,936,800.00 | 352,350,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 2,485,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,485,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,196,000.00 | 29,150,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,196,000.00 | 29,150,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 23,266,708.00 | 22,131,780.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,239,788.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,026,920.00 | 22,131,780.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **376,399,508.00** | **399,503,380.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **376,399,508.00** | **399,503,380.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **372,641,302.00** | **397,324,502.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,577,630.00 | 284,216,427.00 |
| 210101 | Үндсэн цалин | 189,378,030.00 | 196,529,950.00 |
| 210102 | Нэмэгдэл | 47,271,200.00 | 68,106,995.48 |
| 210104 | Урамшуулал | 13,928,400.00 | 19,579,481.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,032,913.00 | 34,439,314.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,980,849.00 | 23,800,438.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,508,700.00 | 2,539,956.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,024,164.00 | 2,191,063.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 501,700.00 | 537,141.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,017,500.00 | 5,370,716.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,102,550.00 | 24,244,405.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,281,734.00 | 3,013,888.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,820,816.00 | 21,230,517.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,973,390.00 | 21,976,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,628,800.00 | 1,700,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,371,800.00 | 13,800,510.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,972,990.00 | 2,014,210.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,999,800.00 | 1,910,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 2,550,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,815,714.00 | 17,912,278.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,183,634.00 | 9,103,898.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 7,184,080.00 | 6,298,380.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,448,000.00 | 2,510,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,005,000.00 | 4,900,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,795,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 3,810,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,400,000.00 | 4,900,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,814,000.00 | 1,274,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,814,000.00 | 1,274,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,920,105.00 | 7,962,068.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,920,105.00 | 7,962,068.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,758,206.00** | **2,178,878.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,239,788.00 | 00.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,239,788.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 693,450.00 | 6,495.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 693,450.00 | 6,495.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,824,968.00 | 2,172,383.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,824,968.00 | 2,172,383.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **6,615,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **6,615,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **6,615,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 6,615,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 6,615,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-6,615,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -70,436,433.54 | 00.00 | 600,781,688.39 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -70,436,433.54 | **00.00** | 600,781,688.39 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 6,284,361.51 | 00.00 | 6,284,361.51 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -64,153,272.03 | **00.00** | 607,064,849.90 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -64,153,272.03 | **00.00** | 607,064,849.90 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -64,153,272.03 | **00.00** | 607,064,849.90 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 20,338,739.49 | 00.00 | 20,338,739.49 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -43,814,532.54 | **00.00** | 627,403,589.39 |

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 403,636,200.00 | 401,454,502.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 403,636,200.00 | 401,454,502.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 403,636,200.00 | 401,454,502.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 284,386,100.00 | 284,216,427.00 |
| 210101 | Үндсэн цалин | 199,303,600.00 | 196,529,950.00 |
| 210102 | Нэмэгдэл | 65,402,600.00 | 68,106,995.48 |
| 210104 | Урамшуулал | 19,679,900.00 | 19,579,481.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,548,300.00 | 34,439,314.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,172,800.00 | 23,800,438.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,843,900.00 | 2,539,956.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,275,100.00 | 2,191,063.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 568,800.00 | 537,141.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,687,700.00 | 5,370,716.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,250,900.00 | 24,244,405.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,014,900.00 | 3,013,888.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,236,000.00 | 21,230,517.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,967,400.00 | 22,456,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,700,800.00 | 1,700,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,800,600.00 | 13,800,510.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 2,014,210.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 1,910,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,450,000.00 | 3,030,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,913,800.00 | 17,912,278.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,103,800.00 | 9,103,898.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,298,380.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,510,000.00 | 2,510,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,550,000.00 | 8,550,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,650,000.00 | 3,650,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,900,000.00 | 4,900,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,657,200.00 | 1,274,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,657,200.00 | 1,274,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7962500.00 | 7962068.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,962,500.00 | 7,962,068.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 403,636,200.00 | 401,454,502.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 352,350,700.00 | 350,178,317.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 352,350,700.00 | 350,178,317.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,150,900.00 | 29,144,405.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,150,900.00 | 29,144,405.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,134,600.00 | 22,131,780.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,134,600.00 | 22,131,780.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 23.00 | 24.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 06.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | 00.00 | 1,467.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 00.00 | 272.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо | 00.00 | 1,195.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **23.00** | **24.00** |

005 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17.00 | 17.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 07.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **2,485,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **2,485,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 2,485,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 2485000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,485,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 2485000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 2,485,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,485,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЭМТ-ийн дарга Б.Үүрийнтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 30-наас 2021 оны 02 дугаар сарын О4–ны хооронд "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 61 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ нь тайлант хугацаанд "Хүнд амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, жигд, хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний чанарыг сайжруулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 446586.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8931.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 627403.6 мянган төгрөг болж өмнөх оноос 20139.3 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 16879.4 | 24709.9 | 7830.5 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 16879.4 | 24407.9 | 7830.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 590384.9 | 602693.7 | 12308.8 |
| Үндсэн хөрөнгө | 709770.1 | 757165.1 | 47395.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -119385.2 | -154471.5 | -35086.3 |
| Нийт хөрөнгө | 607264.3 | 627403.6 | 20139.3 |
| Өр төлбөр | 199.5 | 0 | -199.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 607064.8 | 627403.6 | 20338.8 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 607264.3 | 627403.6 | 20139.3 |

Авлага данс өмнөх оны үлдэгдэл байхгүй, тайлант онд үүссэн авлагыг тухай бүр барагдуулж авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24407.9 мянган төгрөг болж 7830.5 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой ЭМГ болон иргэн, ААНБ-аас 8522.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл , хамгаалах хэрэгсэл, шатахууныг оны эцсээр үнэ төлбөргүй олгосонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 757165.1 мянган төгрөг болж 47395.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6615.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, ЭМЯ-наас УТХО-аар 37900.0 мянган төгрөгийн Фургон автомашин олгосон / доторлогооны зардлыг нэмж орлогод авсан/ , ажиллагсдын хандивын эх үүсвэрээр 2880.0 мянган төгрөгөөр эд хогшил бэлтгэсэн нь үндсэн хөрөнгийн дүнгийн өсөлтөд нөлөөлсөн байна.Тайлант онд үндсэн хөрөнгө данснаас хасаагүй байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 3085.7 мянган төгрөг байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 627403.6 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 20338.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 466924.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 66086,0 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 36367.1 мянган төгрөгөөр өссөн, тусгай зориулалтын шилжүүлгээр авах санхүүжилт 23413.9 мянга, орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилт 4954.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 352350.7 мянган төгрөгийн , орон нутгийн төсвөөс 29150.9 мянган төгрөгийн, ЭМД-аас 22131.8 мянган төгрөгийн, нийт 403633.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 2485.0 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрснийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Батлагдсан төсөвт нийт зардал 401454.5 мянган төгрөг болж өмнөх оноос 28813.2 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой цалин , НДШ-ийн зардал 37045.2 мянган төгрөгөөр өсөж, ЭМТ-ийн эмийг ЭМГ-аас тендер зарлаж нийлүүлэх болсонтой холбоотой нормативт зардал 8903.4 мянган төгрөгөөр, эд хогшил бэлтгэх болон урсгал засварын зардал 6105.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд аудит хийхэд системийн дээд байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний статистик тоон мэдээллийг ЭМЯ-д хүргүүлж түүнд үндэслэн төсвийн төсвийг боловсруулдаг тул байгууллагаар төсвийн төсөл боловсруулдаггүй гэсэн тайлбарыг аймгийн ЭМГ-ын төсвийн мэргэжилтэн н.Гэрэлчулуун өгсөн бөгөөд тухайн байгууллага дээр төсвийн төсөл нэгтгэсэн дүнгээр боловсруулаагүй байна. 2019 оны шилэн дансны мэдээллээс авч үзэхэд төсвийн төсөл дараах байдалтай байна.

Үүнд:

Шилэн дансанд тавигдсан төсвийн төсвийн мэдээлэл.

| Д.Д | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Төслөөрхи дүн | Батлагдсан дүн | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалингийн зардал | Мян.төгрөг | 356243.8 | 284386.1 | -71857.7 |
| 2 | БГАҮ-ний хөлс төлбөр | Мян.төгрөг | 728.2 | 400.0 | -328.2 |
| 3 | Гэрэл цахилгаан | Мян.төгрөг | 6589.4 | 3014.9 | -3574.5 |
| 4 | Түлш халаалт | Мян.төгрөг | 42159.9 | 21236.0 | -20923.9 |
| 5 | Цэвэр бохир ус | Мян.төгрөг | 750.0 | | -750.0 |
| 6 | Урсгал засвар | Мян.төгрөг | 4650.0 | 4900.0 | 250.0 |
| 7 | Сэлбэг хэрэгсэл | Мян.төгрөг | 2025.0 | | -2025.0 |
| 8 | Тавилга эд хогшил | Мян.төгрөг | 9980.0 | 3650.0 | -6330.0 |
| 9 | Шуудан холбоо | Мян.төгрөг | 2520.0 | 2016.0 | -504.0 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ДҮН** | | **425646.3** | **319603.0** | **-106043.3** |

Төсвийн захирагчийн хүргүүлсэн 9 төрлийн 425646.3 мянган төгрөгийн зардлын төсвийн төслөөс дүнгээрээ 106043.3 мянган төгрөг хасагдаж батлагдсан бөгөөд бусад зардлын хувьд статистик тоон мэдээлэлд үндэслэн ЭМЯ төсвийг боловсруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1."Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 403636,2 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 352350.7 мянган төгрөгийн , орон нутгийн төсвөөс 229150.9 мянган төгрөгийн, ЭМД-аас 22134.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан төсвийн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 401454.5 мянган төгрөгийг зарцуулж 2181.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401454.5 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 511.4 мянган, томилолтын зардлыг 383.2 мянган, АО-чоос төлөх НДШ-ийн зардлыг 1108.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 81603 буюу үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ арга хэмжээний НДШ-ийн зардал 1108.9 мянга, хангамж хангамж бараа материалын зардал 511.4 мянган төгрөгөөр, томилолтын зардал 383.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. ТГ бүлэгтэй тайлан /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ХӨТӨЛБӨР 71602** | | | | |
| **АРГА ХЭМЖЭЭ 80109** | | | | |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | -29150.9 | -29150.9 | 0 | 100 |
| Гэрэл, цахилгаан | 3,014,9 | 3,013,9 | 1,0 | 99.9 |
| Түлш, халаалт | 21,236,0 | 21,230,5 | 5,5 | 99.9 |
| Цэвэр, бохир ус | 0 | 0 | 0 | |
| Урсгал засвар | 4,900,0 | 4,900,0 | 0 | 100 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 6,5 | -6,5 | |
| **АРГА ХЭМЖЭЭ 80302** | | | | |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн | -14,204,1 | -14,204,1 | 0 | 100 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,191,6 | 2,191,6 | 0 | 100 |
| Багаж, техник, хэрэгсэл | 3,650,0 | 3,650,0 | 0 | 100 |
| Аудит бат, зэрэглэл тогтоох | 400,0 | 400,0 | 0 | 100 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 7,962,5 | 7,962,1 | 0.4 | 99.9 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 432 | -0.4 | |
| **АРГА ХЭМЖЭЭ 81603** | | | | |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | -0.1 | 0 | -0.1 | 0 |
| Хандив тусламж-дотоод | -22,134,6 | -22,131,8 | -2,8 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтын шилжүүлгийн | 338,146,6 | 338,146,6 | 0 | 100.0 |
| Үндсэн цалин | 199,303,6 | 196,529,9 | 2,773,6 | 98.6 |
| Нэмэгдэл | 65,402,6 | 68,106,9 | -2,7 | 104.1 |
| Урамшуулал | 19,679,9 | 19,579,5 | 100,4 | 99.5 |
| Гэрээт ажлын цалин | 0 | 0 | 0 | |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 24,172,8 | 23,800,4 | 372,4 | 98.5 |
| Тэтгэмжийн даатгал | 2,843,9 | 2,539,9 | 303,9 | 89.3 |
| ҮОМШ-ний даатгал | 2,275,1 | 2,191,0 | 84,0 | 96.3 |
| Ажилгүйдлийн даатгал | 568,8 | 537,1 | 31,6 | 94.4 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,687,7 | 5,370,7 | 316,9 | 94.4 |
| Бичиг хэрэг | 1,700,8 | 1,700,8 | 0 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 13,800,6 | 13,800,5 | 0.1 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэт | 2,016,0 | 2,014,2 | 1,8 | 99.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон | 2,000,0 | 1,910,4 | 89,6 | 95.5 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 3,450,0 | 3,030,1 | 419,9 | 87.8 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,912,3 | 6,912,3 | | 100.0 |
| Хоол, хүнс | 6,300,0 | 6,298,4 | 1,6 | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,510,0 | 2,510,0 | 0 | 100.0 |
| Урсгал засвар | 0 | 0 | 0 | |
| Дотоод албан томилолт | 1,657,2 | 1,274,0 | 383,2 | 76.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 0 | 0 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 2,171,9 | -2,171,9 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шинэ машины доторлогоо, бэхэлгээний зардалд Орон нутгийн төсвөөс 2485.0 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж холбогдох дансаар тайлагнасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 5 | 4 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Сар бүр | 5 | 36 | 35 | 1 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | | |
| | | 29 | 151 | 144 | 5 | 2 |

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Хугацаа хоцроосон мэдээлэл нь бүтэн жилээр мэдээлэх Тухайн жилийн батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө,гүйцэтгэл, Аудитын тайлан ,дүгнэлт,зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон сар бүр мэдээлэх Төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарын 12 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өглөг авлагагүй ажиллах, сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгохгүй байх 3 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан тухай 2020.05.20- ны 28 тоот албан бичгээр ТАБ-д хариу ирүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 234.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил илрээгүй болно.

**Аудитын зөвлөмж**

1 Аудитаар цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолох явцад НДШ-ийн тайлан болон НДБ-тай тооцоо нийлсэн актаар өглөг, авлагын зөрүүгүй гарсан боловч НДХ-ээс ирүүлсэн тооцоогоор 234.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсан нь хөнгөлөлттэй нөхцөлөөр шимтгэл төлсөн ажилтны шимтгэлийн хувь хэмжээний зөрүүний залруулгыг НД-ын байгууллага тухайн санхүүгийн тайлан гарснаас хойш хийж ирүүлсэнтэй холбоотой үүссэн авлага тул зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал нь шатахууны тооцоо бодолтын байдал, нярвын эмийн зарцуулалтын тайлан гаргалтад анхаарал хандуулах шаардлагатай.

### Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

1.1. <u>Илрүүлэлт:</u> Цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолох явцад НДШ-ийн тайлан болон НДБ-тай тооцоо нийлсэн актаар өглөг, авлагын зөрүүгүй гарсан боловч НДХ-ээс ирүүлсэн тооцоогоор 234.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсан нь хөнгөлөлттэй нөхцөлөөр шимтгэл төлсөн ажилтны шимтгэлийн хувь хэмжээний зөрүүний залруулгыг НД-ын байгууллага тухайн санхүүгийн тайлан гарснаас хойш хийж ирүүлсэнтэй холбоотой үүссэн авлага байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зөөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

*Зөрчсөн батламж мэдэгдэл: Үнэн, зөв байдал, Толилуулга*

*1.2. <u>Эрсдэл:</u> Өглөг, авлага санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх*

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>: НДШ-ийн тайлангаар гарсан илүү төлөлтийн 234.0 мянган төгрөгийг 2021 оны 3-р сарын цалингийн төлөлтөөс суутган тооцож зөрчлийг арилгах*

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА
Огноо: 2021.02.05

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.05

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.05

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт :Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/121/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн Жинст сумын ЭМТ | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | НДШ-ийн илүү төлөлтийн 234.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй | 234.0 | Зөвлөмж өгөх | Дарга | Б.Үүрийнтуяа , |
| **ДҮН** | | **234.0** | | | |